



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/02.

Чингис хот

**Галын аюулгүй байдал хариуцсан
албан тушаалтан томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын галын аюулгүй байдал хариуцсан албан тушаалтнаар Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалт хариуцсан офицер дэд хурандаа Т.Баярааг томилсугай.

Хоёр. Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагчийн 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 02/07 дугаар албан шаардлагын дагуу зөрчлийг арилгах төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг дэд хурандаа Т.Баяраад даалгасугай.

Гурав. Галын аюулгүй байдал хариуцсан албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цэргийн штабын дарга /дэд хурандаа Н.Хүрэлээ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

03 004